УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөрхангай сум дахь Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/74/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Амармэнд

Утас: 70453721, Цахим хаяг: ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.......2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......3
3. Аудитын тайлан.......12
3.1 Ерөнхий зүйл.......12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.......12
3.4 Материаллаг байдал.......13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.......14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......14
3.8 Аудитын гол асуудал.......14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.......15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.......15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022. 02. 25 № УВА-2022/74/НА-СТА-ТШЗ
танай ______ -ны № ______ -т

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН СУМ
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
А.ТӨРТОГТОХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өндөрхангай сумын Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200423

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,911,580.00** | **13,301,580.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 12,911,580.00 | 13,301,580.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,911,580.00 | 13,301,580.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 733,200.00 | 733,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,178,380.00 | 12,498,380.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 70,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **54,098,966.08** | **44,257,384.73** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 54,098,966.08 | 44,257,384.73 |
| **392** | **Биет хөрөнгө** | 51,122,966.08 | 41,281,384.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 15,482,368.42 | 15,482,368.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,387,371.84 | -1,809,313.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 60,966,305.00 | 60,966,305.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -32,819,429.52 | -38,759,385.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 27,271,405.16 | 23,970,036.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -22,930,873.70 | -21,265,123.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,676,729.68 | 6,615,062.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,675,185.11 | -6,030,860.97 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,483,609.60 | 7,483,609.60 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,944,591.61 | -5,371,313.49 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2,976,000.00 | 2,976,000.00 |
| 39301 | Программ хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770,000.00 | -770,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,976,000.00 | 2,976,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **67,010,546.08** | **57,558,964.73** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **51,410.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 51,410.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 51,410.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 51,410.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 51,410.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **67,010,546.08** | **57,507,554.73** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 67,010,546.08 | 57,507,554.73 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 24,118,947.33 | 24,118,947.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 24,118,947.33 | 24,118,947.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 31,687,416.93 | 22,184,425.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 31,687,416.93 | 31,687,416.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -9,502,991.35 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,204,181.82 | 11,204,181.82 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **67,010,546.08** | **57,558,964.73** |

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **54,554,200.00** | **51,817,800.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,870,000.00** | **2,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,870,000.00 | 2,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,870,000.00 | 2,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,870,000.00 | 2,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **51,684,200.00** | **49,817,800.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,400.00 | 840,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,400.00 | 840,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 51,674,800.00 | 48,977,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,674,800.00 | 48,977,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **65,609,271.19** | **61,320,791.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **65,609,271.19** | **61,320,791.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 63,330,701.19 | 58,541,993.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 36,638,672.00 | 35,749,017.00 |
| 210101 | Үндсэн цалин | 36,638,672.00 | 35,749,017.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,579,838.00 | 4,648,894.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,111,840.00 | 3,218,766.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 367,000.00 | 357,532.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 293,600.00 | 286,026.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 73,400.00 | 71,506.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 733,998.00 | 715,062.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,807,526.00 | 2,012,043.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 55,663.00 | 129,697.21 |
| 210302 | Түлш, халаалт | 1,751,863.00 | 1,882,346.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,939,480.00 | 4,735,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,133,640.00 | 464,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,454,940.00 | 3,101,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 119,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 101,000.00 | 20,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,949,900.00 | 1,029,700.00 |
| **2105** | **Норматив зардал** | 3,268,000.00 | 320,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,629,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,639,000.00 | 320,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,024,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,024,000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 288,000.00 | 215,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 288,000.00 | 215,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 564,654.00 | 400,258.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 108,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,450.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 60,000.00 | 71,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 304,300.00 | 110,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 11,904.00 | 23,808.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,220,531.19 | 10,461,581.35 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,220,531.19 | 10,461,581.35 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,278,570.00 | 2,778,797.59 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,270,000.00 | 2,353,941.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,270,000.00 | 2,353,941.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 424,856.59 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 424,856.59 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,008,570.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,008,570.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-11,055,071.19** | **-9,502,991.35** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-11,055,071.19** | **-9,502,991.35** |

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **54,554,200.00** | **51,817,800.00** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,870,000.00** | **2,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,870,000.00 | 2,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,870,000.00 | 2,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,870,000.00 | 2,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **51,684,200.00** | **49,817,800.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,400.00 | 840,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,400.00 | 840,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 51,674,800.00 | 48,977,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,674,800.00 | 48,977,800.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **54,554,200.00** | **51,817,800.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **54,554,200.00** | **51,817,800.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **52,275,630.00** | **49,039,002.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 36,668,722.00 | 35,749,014.00 |
| 210101 | Үндсэн цалин | 36,668,722.00 | 35,749,014.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,549,788.00 | 4,648,897.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,081,788.00 | 3,218,766.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 367,000.00 | 357,532.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 293,600.00 | 286,026.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 73,400.00 | 71,506.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 734,000.00 | 715,065.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,871,776.00 | 2,012,043.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 89,913.00 | 129,697.21 |
| 210302 | Түлш, халаалт | 1,751,863.00 | 1,882,346.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 30,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,745,690.00 | 3,873,790.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 500,000.00 | 450,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,371,490.00 | 2,949,690.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 119,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 139,200.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 435,000.00 | 233,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 640,000.00 | 640,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 640,000.00 | 640,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,683,000.00 | 1,500,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 744,000.00 | 620,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,939,000.00 | 880,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 288,000.00 | 215,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 288,000.00 | 215,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 564,654.00 | 400,258.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 108,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 71,000.00 | 71,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 304,300.00 | 110,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 11,904.00 | 23,808.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 264,000.00 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 264,000.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,278,570.00** | **2,778,797.59** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,270,000.00 | 2,353,941.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,270,000.00 | 2,353,941.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,008,570.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,008,570.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 424,856.59 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 424,856.59 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **00.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **24,118,947.33** | **11,204,181.82** | **42,742,488.12** | 78,065,617.27 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **24,118,947.33** | **11,204,181.82** | **42,742,488.12** | 78,065,617.27 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -11,055,071.19 | -11,055,071.19 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **24,118,947.33** | **11,204,181.82** | **31,687,416.93** | 67,010,546.08 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **24,118,947.33** | **11,204,181.82** | **31,687,416.93** | 67,010,546.08 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **24,118,947.33** | **11,204,181.82** | **31,687,416.93** | 67,010,546.08 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 9,580,000.00 | 00.00 | 9,502,991.35 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -9,580,000.00 | -9,502,991.35 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **24,118,947.33** | **11,204,181.82** | **22,184,425.58** | 57,507,554.73 |

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/ төгрөгөөр /**

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 51,605,400.00 | 50,552,943.41 | 1,052,456.59 | 98.0% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 51,605,400.00 | 50,552,943.41 | 1,052,456.59 | 98.0% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 50,071,800.00 | 49,039,002.41 | 1,032,797.59 | 97.9% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 35,755,300.00 | 35,749,014.00 | 6,286.00 | 100.0% |
| 210101 | Үндсэн цалин | 35,755,300.00 | 35,749,014.00 | 6,286.00 | 100.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,954,300.00 | 4,648,897.00 | 305,403.00 | 93.8% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,486,300.00 | 3,218,766.52 | 267,533.48 | 92.3% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 367,000.00 | 357,532.62 | 9,467.38 | 97.4% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 293,600.00 | 286,026.12 | 7,573.88 | 97.4% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 73,400.00 | 71,506.50 | 1,893.50 | 97.4% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 734,000.00 | 715,065.24 | 18,934.76 | 97.4% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,427,300.00 | 2,012,043.41 | 415,256.59 | 82.9% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 426,500.00 | 129,697.21 | 296,802.79 | 30.4% |
| 210302 | Түлш, халаалт | 1,960,800.00 | 1,882,346.20 | 78,453.80 | 96.0% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 40,000.00 | 00.00 | 40,000.00 | 0.0% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,943,300.00 | 3,873,790.00 | 69,510.00 | 98.2% |
| 210401 | Бичиг хэрэг | 500,000.00 | 450,500.00 | 49,500.00 | 90.1% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,949,700.00 | 2,949,690.00 | 10.00 | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 119,900.00 | 119,900.00 | 0.00 | 100.0% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,000.00 | 120,000.00 | 20,000.00 | 85.7% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 233,700.00 | 233,700.00 | 0.00 | 100.0% |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 | 0.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 640,000.00 | 640,000.00 | 0.00 | 100.0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 640,000.00 | 640,000.00 | 0.00 | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 620,000.00 | 620,000.00 | 0.00 | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 880,000.00 | 880,000.00 | 0.00 | 100.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 215,000.00 | 215,000.00 | 0.00 | 100.0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 215,000.00 | 215,000.00 | 0.00 | 100.0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 504,600.00 | 400,258.00 | 104,342.00 | 79.3% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 108,000.00 | 0.00 | 100.0% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 103,300.00 | 54,450.00 | 48,850.00 | 52.7% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,700.00 | 71,000.00 | 9,700.00 | 88.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 | 0.00 | 100.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 110,000.00 | 110,000.00 | 0.00 | 100.0% |
| 210807 | Газрын төлбөр | 69,600.00 | 23,808.00 | 45,792.00 | 34.2% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 132000.00 | 0.00 | 132,000.00 | 0.0% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 132,000.00 | 00.00 | 132,000.00 | 0.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1533600.00 | 1513941.00 | 19,659.00 | 98.7% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,533,600.00 | 1,513,941.00 | 19,659.00 | 98.7% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,533,600.00 | 1,513,941.00 | 19,659.00 | 98.7% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 51,605,400.00 | 50,977,800.00 | 627,600.00 | 98.8% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 49,605,400.00 | 48,977,800.00 | 627,600.00 | 98.7% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 49,605,400.00 | 48,977,800.00 | 627,600.00 | 98.7% |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | 0.00 | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.0% |
| 120004 1 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.0% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 0.00 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 0.00 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 04.00 | 04.00 | 0.00 | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 0.00 | |
| 620004 | Гэрээт ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **04.00** | **04.00** | 0.00 | 100.0% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 03.00 | 03.00 | 0.00 | 100.0% |
| 650010 | Гэрээт ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0% |

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/ төгрөгөөр /**

| **код** | **Үзүүлэлт** | **төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **840,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **840,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 840,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 840,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 840000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 840,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 840,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Өндөрхангай сум дахь сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сум дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өндөрхангай сум дахь сум дундын ойн анги нь хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд Ойн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврын хэрэгжилтийг хангах нөхөрлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар ойн санг тогтвортой урт хугацаанд хамгаалахаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн талаар хяналт мониторинг хийсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сум дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 524.8 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 55,543.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 555.4 мянган төгрөгийн 80 хувиар буюу 444.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өндөрхангай сум дахь сум дундын ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,486.0 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 12,911.5 | 13,301.5 | 390.0 |
| Үндсэн хөрөнгө | 54,098.9 | 44,257.3 | -9,841.6 |
| **Нийт хөрөнгө** | 67,010.5 | 57,558.9 | -9,451.6 |
| Өр төлбөр | 0.0 | 0.5 | 0.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 67,010.5 | 57,507.5 | -9,503.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 67,010.5 | 57,558.9 | -9,451.6 |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,301.5 мянган төгрөг болж 390.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн бараа байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44,257.3 мянган төгрөг болж 9,841.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 620.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ашиглалтын хугацаа дууссан 4,983.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны 57,507.5 мянган төгрөг болж 9,503.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,736.4 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 4,288.4 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Энэ нь хангамжийн бараа материалын зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Тайлант онд шатахууны 0.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өндөрхангай сум дахь сум дундын ойн ангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 51,487.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 51,487.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 18.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 51,505.4 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийж 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 51,605.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 51,605.4 мянган төгрөгийн төсөв батласнаас 49,605.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 48,552.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 50,552.9 мянган төгрөгийг зарцуулж, 424.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 50,552.9 мянган төгрөг буюу 90. хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 840.0 мянган төгрөг хуваарилсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар албан шаардлага өгсөн тул А/108 дугаар тушаалаар өгсөн ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцорсон 1, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 224.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулан ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Т.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ний өдөр